



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.20

№

153

танай

-ы №

-т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Н.НЯМХАТАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг 1 төлбөрийн акт, 1 албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт *dd* хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ж. ГАНБААТАР
Ж. ГАНБААТАР



232503153

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2025/006/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.20 № 101

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Н.НЯМХАТАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 1,560.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 5.0 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөд 12.0 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөд 0.3 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,562.1 сая төгрөгийг зарцуулан, улсын төсөвт 57.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын газар нь үйлчилгээний зааланд 26.0 сая төгрөгөөр засвар, тохижилтын ажил хийж албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас киоск машин байршуулж, иргэд, даатгуулагчдад 18 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг хурдан шуурхай авах боломжийг бүрдүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 12,208.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас 10,931.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоож, нягтлан бодогчид 1,277.0 мянган төгрөгийн урамшууллыг төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

232502101

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ тусгаж, 88 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,438,378.46	47,648,027.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,311,567.33	11,567.33
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,311,567.33	11,567.33
31210	Төгрөг	1,311,567.33	11,567.33
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,311,567.33	11,567.33
33	АВЛАГА	443,707.13	-
33500	Бусад авлага	443,707.13	-
33510	Байгууллагаас авах авлага	443,707.13	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	25,683,104.00	47,636,460.00
35400	Хангамжийн материал	25,683,104.00	47,636,460.00
35410	Бичиг хэргийн материал	3,431,750.00	4,992,850.00
35420	Аж ахуйн материал	19,353,656.00	22,842,156.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	9,186,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,163,286.00	2,167,286.00
35450	Барилгын засварын материал	1,161,950.00	7,250,600.00
35470	Бусад хангамжийн материал	572,462.00	1,197,568.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	342,439,935.64	334,708,981.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	342,439,935.64	334,708,981.85
39200	Биет хөрөнгө	320,289,021.44	314,058,981.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	282,651,815.00	282,651,815.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,321,456.54)	(78,739,252.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,996,000.00	17,996,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,599,199.96)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	146,037,663.58	150,989,667.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,146,662.86)	(70,775,712.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,220,500.00	51,526,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,148,837.74)	(35,990,535.42)
39300	Биет бус хөрөнгө	22,150,914.20	20,650,000.00
39301	Программ хангамж	1,500,914.20	1,500,914.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,500,914.20)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,650,000.00	20,650,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	369,878,314.10	382,357,009.18
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,400.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,400.00	-
41300	Өглөг	6,400.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,400.00	-
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	369,871,914.10	382,357,009.18
51	Засгийн газрын хувь оролцоо	369,871,914.10	382,357,009.18
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	284,367,256.89	284,367,256.89
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	284,367,256.89	284,367,256.89
51200	Хуримтлагдсан үр дүн	74,757,609.21	87,242,704.29
51210	Өмнөх үеийн үр дүн	74,757,609.21	74,757,609.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	12,485,095.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,747,048.00	10,747,048.00
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	369,878,314.10	382,357,009.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,341,020,090.01	1,601,748,796.40
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,237,590.01	23,624,096.40
3	Нийтлэг татварын бус орлого	23,237,590.01	23,624,096.40
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,237,590.01	23,624,096.40
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	23,237,590.01	22,092,096.40
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,532,000.00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,317,782,500.00	1,578,124,700.00
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,300,000.00
9	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,000,000.00
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,000.00
11	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.00
12	Төсвийн захирагчдаас	3,209,200.00	1,560,824,700.00
13	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,560,824,700.00
14	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,209,200.00	-
15	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,314,573,300.00	-
16	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,314,573,300.00	-
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,354,685,660.04	1,589,263,701.32
18	УРСГАЛ ЗАРДАЛ	1,354,685,660.04	1,589,263,701.32
19	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,154,339,376.74	1,406,123,266.18
20	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	872,668,310.97	1,127,299,033.61
21	Үндсэн цалин	494,609,628.96	657,584,683.63
22	Нэмэгдэл	223,711,225.48	315,989,399.39
23	Унаа хоолны хөнгөлөлт	35,207,766.93	52,923,237.50
24	Урамшуулал	119,139,689.60	100,801,713.09
25	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,141,060.95	141,148,419.61
26	Тэтгэврийн даатгал	76,555,761.43	97,598,692.52
27	Тэтгэмжийн даатгал	8,946,769.91	11,293,190.26
28	ҮОМШӨ-ний даатгал	6,946,126.08	5,833,247.90
29	Ажилгүйдлийн даатгал	1,578,983.40	5,210,634.79
30	Эрүүл мэндийн даатгал	16,113,420.13	21,212,654.14
31	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,079,748.52	37,998,760.46
32	Гэрэл, цахилгаан	3,950,744.04	4,768,468.46
33	Түлш, халаалт	28,095,307.48	30,917,487.00
34	Цэвэр, бохир ус	2,033,697.00	2,312,805.00
35	Хангамж, бараа материалын зардал	18,630,133.10	16,241,323.31
36	Бичиг хэрэг	8,593,800.00	7,971,900.00
37	Тээвэр, шатахуун	4,996,000.00	2,496,000.00
38	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,472,384.10	2,624,623.31
39	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,400.00	332,400.00
40	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,977,415.00	2,816,400.00
41	Бараа материал акталсны зардал	258,134.00	-
42	Эд хогшил, урсгал засварын зардал	31,381,647.00	23,936,260.00
43	Урсгал засвар	31,381,647.00	23,936,260.00
44	Томилолт, зочны зардал	11,630,000.00	6,142,000.00
45	Дотоод албан томилолт	11,630,000.00	6,142,000.00
46	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,078,861.00	4,209,219.00

47	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,343,900.00	2,970,800.00
48	Даатгалын үйлчилгээ	646,875.00	625,675.00
49	Тээврийн хэрэгслийн татвар	92,700.00	74,200.00
50	Газрын төлбөр	45,264.00	20,650.00
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	207,700.00	153,000.00
52	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,742,422.00	364,894.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	63,729,615.20	49,148,250.19
54	Бараа үйлчилгээний бусад зардал	-	111,500.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	1,863,900.00
56	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,479,615.20	47,172,850.19
57	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,346,283.30	183,140,435.14
58	Бусад урсгал шилжүүлэг	9,911,060.00	125,719,640.00
59	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,911,060.00	15,108,000.00
60	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	109,311,640.00
61	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,300,000.00
62	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	57,420,795.14
63	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	57,420,795.14
64	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	190,435,223.30	-
65	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,435,223.30	-
66	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(13,665,570.03)	12,485,095.08
67	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(13,665,570.03)	12,485,095.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,314,810,138.00	1,578,124,700.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	236,838.00	-
3	Нийтлэг татварын бус орлого	236,838.00	-
4	Бусад орлого	236,838.00	-
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,314,573,300.00	1,578,124,700.00
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,300,000.00
7	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,000,000.00
8	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,000.00
9	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.00
10	Төсвийн захирагчдаас	-	1,560,824,700.00
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,560,824,700.00
12	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,314,573,300.00	-
13	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,314,573,300.00	-
14	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,313,847,610.88	1,562,074,900.00
15	УРСГАЛ ЗАРДАЛ	1,313,847,610.88	1,562,074,900.00
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,115,243,854.70	1,378,934,464.86
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	872,894,491.13	1,126,861,726.48
18	Үндсэн цалин	494,835,809.12	619,947,271.46
19	Нэмэгдэл	223,711,225.48	353,189,504.43
20	Унаа хоолны хөнгөлөлт	35,207,766.93	52,923,237.50
21	Урамшуулал	119,139,689.60	100,801,713.09
22	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,141,060.95	141,148,419.61
23	Тэтгэврийн даатгал	76,555,761.43	97,598,692.52
24	Тэтгэмжийн даатгал	8,946,769.91	11,293,190.26
25	ҮОМШӨ-ний даатгал	6,946,126.08	5,833,247.90
26	Ажилгүйдлийн даатгал	1,578,983.40	5,210,634.79
27	Эрүүл мэндийн даатгал	16,113,420.13	21,212,654.14
28	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,003,873.52	37,998,760.46
29	Гэрэл, цахилгаан	3,950,744.04	4,768,468.46
30	Түлш, халаалт	35,019,432.48	30,917,487.00
31	Цэвэр, бохир ус	2,033,697.00	2,312,805.00
32	Хангамж, бараа материалын зардал	35,207,555.10	21,217,923.31
33	Бичиг хэрэг	9,608,200.00	8,456,000.00
34	Тээвэр, шатахуун	5,427,100.00	3,500,000.00
35	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,472,384.10	2,624,623.31
36	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,400.00	332,400.00
37	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,367,471.00	6,304,900.00
38	Эд хогшил, урсгал засварын зардал	32,543,597.00	38,668,910.00
39	Багаж, техник, хэрэгсэл	-	8,644,000.00
40	Урсгал засвар	32,543,597.00	30,024,910.00
41	Томилолт, зочны зардал	11,630,000.00	6,142,000.00
42	Дотоод албан томилолт	11,630,000.00	6,142,000.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,336,439.00	4,921,325.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,343,900.00	4,047,800.00
45	Даатгалын үйлчилгээ	646,875.00	625,675.00
46	Тээврийн хэрэгслийн татвар	92,700.00	74,200.00
47	Газрын төлбөр	45,264.00	20,650.00

48	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	207,700.00	153,000.00
49	Бараа үйлчилгээний бусад зардал	1,486,838.00	1,975,400.00
50	Бараа үйлчилгээний бусад зардал	236,838.00	111,500.00
51	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	1,863,900.00
52	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,603,756.18	183,140,435.14
53	Бусад урсгал шилжүүлэг	9,911,060.00	125,719,640.00
54	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,911,060.00	15,108,000.00
55	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	109,311,640.00
56	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,300,000.00
57	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	57,420,795.14
58	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	57,420,795.14
59	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	188,692,696.18	-
60	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,692,696.18	-
61	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	962,527.12	16,049,800.00
62	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	17,349,800.00
63	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	17,349,800.00
64	Дотоод эх үүсвэрээр	-	17,349,800.00
65	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	17,349,800.00
66	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(17,349,800.00)
67	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	962,527.12	(1,300,000.00)
68	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,091,567.33	1,311,567.33
69	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,311,567.33	11,567.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	88,423,179.24	383,537,484.13
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	88,423,179.24	383,537,484.13
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,665,570.03)	(13,665,570.03)
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	74,757,609.21	369,871,914.10
5	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	74,757,609.21	369,871,914.10
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	74,757,609.21	369,871,914.10
7	Тайлант үеийн үр дүн	-	-	12,485,095.08	12,485,095.08
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	87,242,704.29	382,357,009.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,560,824,700.00	1,503,403,904.86	57,420,795.14
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,560,824,700.00	1,503,403,904.86	57,420,795.14
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,352,600.00	1,378,984,264.86	57,368,335.14
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,165,854,100.00	1,126,861,726.48	38,992,373.52
5	Үндсэн цалин	638,241,200.00	619,947,271.46	18,293,928.54
6	Нэмэгдэл	339,126,900.00	353,189,504.43	(14,062,604.43)
7	Унаа хоолны хөнгөлөлт	76,771,200.00	52,923,237.50	23,847,962.50
8	Урамшуулал	111,714,800.00	100,801,713.09	10,913,086.91
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,241,300.00	141,148,419.61	6,092,880.39
10	Тэтгэврийн даатгал	100,607,100.00	97,598,692.52	3,008,407.48
11	Тэтгэмжийн даатгал	11,658,500.00	11,293,190.26	365,309.74
12	ҮОМШӨ-ний даатгал	5,829,300.00	5,833,247.90	(3,947.90)
13	Ажилгүйдлийн даатгал	5,829,300.00	5,210,634.79	618,665.21
14	Эрүүл мэндийн даатгал	23,317,100.00	21,212,654.14	2,104,445.86
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,465,000.00	37,998,760.46	5,466,239.54
16	Гэрэл, цахилгаан	6,474,200.00	4,768,468.46	1,705,731.54
17	Түлш, халаалт	34,430,200.00	30,917,487.00	3,512,713.00
18	Цэвэр, бохир ус	2,560,600.00	2,312,805.00	247,795.00
19	Хангамж, бараа материалын зардал	18,844,400.00	18,242,923.31	601,476.69
20	Бичиг хэрэг	8,456,000.00	8,456,000.00	-
21	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,500,000.00	-
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,226,100.00	2,624,623.31	601,476.69
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,400.00	332,400.00	-
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,329,900.00	3,329,900.00	-
25	Эд хогшил, урсгал засварын зардал	42,022,700.00	41,993,710.00	28,990.00
26	Багаж, техник, хэрэгсэл	20,022,700.00	19,993,800.00	28,900.00
27	Урсгал засвар	22,000,000.00	21,999,910.00	90.00
28	Томилолт, зочны зардал	5,886,000.00	5,842,000.00	44,000.00
29	Дотоод албан томилолт	5,886,000.00	5,842,000.00	44,000.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,063,700.00	4,921,325.00	6,142,375.00
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,170,200.00	4,047,800.00	1,122,400.00
32	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,905,000.00	-	4,905,000.00
33	Даатгалын үйлчилгээ	637,600.00	625,675.00	11,925.00
34	Тээврийн хэрэгслийн татвар	98,100.00	74,200.00	23,900.00
35	Газрын төлбөр	49,000.00	20,650.00	28,350.00

36	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	203,800.00	153,000.00	50,800.00
37	Бараа үйлчилгээний бусад зардал	1,975,400.00	1,975,400.00	-
38	Бараа үйлчилгээний бусад зардал	111,500.00	111,500.00	-
39	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,863,900.00	1,863,900.00	-
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,472,100.00	124,419,640.00	52,460.00
41	Бусад урсгал шилжүүлэг	124,472,100.00	124,419,640.00	52,460.00
42	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,160,300.00	15,108,000.00	52,300.00
43	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	109,311,800.00	109,311,640.00	160.00
44	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,560,824,700.00	1,503,403,904.86	57,420,795.14
45	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,560,824,700.00	1,503,403,904.86	57,420,795.14
46	Улсын төсвөөс санхүүжих	1,560,824,700.00	1,503,403,904.86	57,420,795.14
47	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	91	77	14
48	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-
49	Төсвийн байгууллага	1	1	-
50	АЖИЛЛАГСДЫН ТОО	45	38	7
51	Удирдах ажилтан	5	1	4
52	Гүйцэтгэх ажилтан	37	34	3
53	Үйлчлэх ажилтан	3	3	-
54	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45	38	7
55	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	39	33	6
56	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	5	1

2.6 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	17,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,300,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,300,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,975,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,975,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,025,000.00
210604	Урсгал засвар	8,025,000.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00
3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	6,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000,000.00
225101	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,000,000.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд “Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болно” гэсэн хэтийн зорилтыг тавьж ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын тухай хуульд Нийгмийн даатгалын байгууллага дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ. Үүнд:

- 1/ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- 2/ нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;
- 3/ нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- 4 /улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- 5/ доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;
- 6/ хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын хяналт шалгалтын газраас болон хяналт, шалгалт дотоод аудитын тасгаас 2024 онд Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны санхүүд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,478.7 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,311.6	11.6	(1,300.0)
Авлага	443.7		(443.7)
Бараа материал	25,683.1	47,636.4	21,953.3
Үндсэн хөрөнгө	342,439.9	334,709.0	(7,730.9)
Нийт хөрөнгө	369,878.3	382,357.0	12,478.7
Өр төлбөр	6.4		(6.4)
Засгийн газрын оруулсан капитал	284,367.3	284,367.3	-
Хуримтлагдсан үр дүн	74,757.6	87,242.7	12,485.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,747.0	10,747.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	369,878.3	382,357.0	12,478.7

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11.6 мянган төгрөг болж оны эхнээс 1,300.0 мянган төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн төрийн сан дахь ахмадын сангийн харилцах дансанд 11.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 443.7 мянган төгрөгөөр буурч үлдэгдэлгүй болсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47,636.4 мянган төгрөг болж, 21,953.3 мянган төгрөгөөр өссөн нь 60,726.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,532.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 40,305.3 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 334,709.0 мянган төгрөг болж, 7,730.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 17,349.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 22,092.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, дээд газрын шийдвэрээр 44,184.2 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 87,242.7 мянган төгрөг болж 12,485.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсөв захирагчийн 2024 оны төсвийн төсөлд нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны урсгал төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 1,709.3 сая төгрөгөөр тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал үйл ажиллагааны төсвийг 215.9 сая төгрөгөөр бууруулж, 1,493.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,560,824.7 мянган төгрөгийн төсөв урсгал зардалд зарцуулахаар тодотгон батлагдсан. Үүнд багаж техник, тавилга эд хогшил худалдан авах зардал нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 1,560,824.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,503,403.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 57,420.8 сая төгрөгийг хэмнэн төсөвт төвлөрүүлж, гүйцэтгэл 96.3 хувьтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,360,641.0	1,317,497.2	43,143.8	96.8
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	4,455.0	940.0	3,515.0	21.1
3	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хө	392.4	251.0	141.4	64.0
4	80219	Харуул, хамгаалалтын зардал	981.0	-	981.0	0.0
5	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	69,883.2	60,296.1	9,587.1	86.3
6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	109,311.8	109,311.6	0.2	100.0
7	80813	Хуульд заасан үндэслэлээр алба	2,256.3	2,204.0	52.3	97.7
8	80820	Бусад тусламж, дэмжлэг	12,904.0	12,904.0	-	100.0
		Дүн	1,560,824.7	1,503,403.9	57,420.8	96.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар 17,300.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийсэн байна. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд 5.0 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн 12.0 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан

хөрөнгийн 0.3 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлж, урсгал засварт 8.0 сая төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс авахад 3.0 сая төгрөг, албан томилолтын зардалд 0.3 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 6.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Аудитын явцад авсан судалгааны талаар:

1. Ахмадын сангийн 2024 оны орлого, зардлын нэгдсэн судалгаагаар ахмадын сангийн эхний үлдэгдэл 1,311.6 мянган төгрөгөөс 1,300.0 мянган төгрөг зарцуулж 11.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зарцуулалтыг авч үзвэл цагаан сарын баяраар ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд зарцуулсан нь Ахмад настны тухай хуулийн холбогдох заалтад нийцсэн байна.
2. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн судалгаагаар тус байгууллага нь 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, гүйцэтгэл байхгүй байна.
3. Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 5,170.2 мянган төгрөгийг зарцуулснаас өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлсний зардалд 392.4 мянган төгрөг, харуул, хамгаалалтын зардалд 981.0 мянган төгрөг, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлсний зардалд 3,796.8 мянган төгрөгийг зарцуулжээ.
4. Төсвөөс 2024 онд зарцуулсан бараа үйлчилгээний бусад зардлаас 111.5 мянган төгрөгийн материал худалдан авсан байна.
5. Байгууллагын 2024 оны орон тооны судалгаагаар 1,165,854.1 мянган төгрөгийн цалингийн сангийн зардал батлагдсанаас 1,126,861.7 мянган төгрөг зарцуулж 38,922.4 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Нийт 45 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 38 орон тоотой ажилласан байна. Үүнд: Удирдах 5, гүйцэтгэх 30, үйлчлэх 3 ажилтан байна. Үүнээс төрийн захиргааны 32, төрийн үйлчилгээний албан хаагч 6 байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03/15 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,315,353.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,153.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,865.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна. Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах горим сорилыг хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг шалгахад мэдээллийг 100 хувьтай мэдээлсэн байна. Үүнд таван сая төгрөгөөс худалдан авалтын 214,193.5 мянган төгрөгийн 8 худалдан авалт, орлогын 1,814,567.3 мянган төгрөгийн 32 гүйлгээ, зарлагын 270,849.1 мянган төгрөгийн 31 гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 14,633.6 мянган төгрөгийн 16 тушаал шийдвэрийг мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тухайн байгууллагад завсрын аудитыг 2024 оны 10 сард 1-9 сарын баримтыг хамруулан хийсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар бараа материалын үлдэгдлийг тоолоогүй зөрчлийг арилгах албан шаардлага, илүү олгосон цалинг төсөвт төвлөрүүлэх зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	352.4	1	352.4	100.0
Албан шаардлага	1	25,683.1	1	25,683.1	100.0
Зөвлөмж					
Нийт дүн	2	26,035.5	2	26,035.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,208.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 10,931.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг дахин давтахгүй байх 1,277.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу төрийн захиргааны 17 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгохдоо 10,931.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Тайлант онд НДЕГ-ын газрын даргын тушаалаар 2023 оны санхүүгийн тайлангаар "Өөрчлөлтгүй дүгнэлт" авсан ахлах нягтлан бодогчид 1,277.0 мянган төгрөгийн урамшууллыг төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийг илүү илэрхийлсэн												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
ХХОАТ суутгаагүй	1	10931.0	1	10931.0								
Урамшуулал давхар олгосон	1	1277.0			1	1277.0						
Дүн	2	12208.0	1	10931.0	1	1277.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
Дүн								
Нийт дүн								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 17-ХЭА-2025/006/НА-СТА-ТШЗ
А2370447 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 10,931.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-т "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй татварын 10,931.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын газрын дарга Н.Нямхатан, нягтлан бодогч А.Оюун нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Н.ТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 07

Дугаар 11-ХЭА-2025/006/НА-СТА-ТШЗ
А 2370447 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

НДЕГ-ын газрын даргын тушаалаар 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй дүгнэлт" авсан ахлах нягтлан бодогч М.Болортуяад үндсэн цалингийн 80 хувиар 1,277.0 мянган төгрөгийг төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Урсгал зардлын ангилалын тайлбар" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын газрын дарга Н.Нямхатан, үйл ажиллагааны нягтлан бодогч А.Оюун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА

232540011